

# “ХӨВСГӨЛ” ХК

2023 оны 11 сарын 13-ний өдөр

№ 13/03

Улаанбаатар хот

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

*Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус  
хурал зарлан хуралдуулах тухай*

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 59.10, 59.11, 60 дугаар зүйл, 61 дүгээр зүйлийн 61.1.5, 71 дүгээр зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.2, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 377 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай журам”, Компанийн дүрмийн 7.4, 7.5 дахь хэсгийг тус тус үндэслэн “Хөвсгөл” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. “Хөвсгөл” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал (цаашид “Хурал” гэх)-ыг **2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 15:00 цагт, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 хороо, Сүхбаатарын талбай - 2, Сентрал Тауэр 17 давхарт** хуралдуулсугай.
2. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг Нэгдүгээр хавсралтаар, Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэгийг Хоёрдугаар хавсралтаар, Саналын хуудасны агуулга, загварыг Гуравдугаар хавсралтаар, Хурлын нийтэд хүргэх зарын загварыг Дөрөвдүгээр хавсралтаар, Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой баримт материалын жагсаалтыг Тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Хуралд оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдрөөр тогтоосугай.
4. Хурлын мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хороо болон Арилжаа эрхлэх байгууллагад 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн дотор хүргүүлсүгэй.
5. Хурал хуралдуулах тухай зар мэдээг Хөрөнгийн биржийн цахим хуудсаар, өдөр тутмын хоёроос доошгүй сонин, бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2023 оны 11 дугаар сарын 18-ны өдрийн дотор нийтэд зарласугай. Давтан зарыг 2023 оны 12 дугаар сарын 03-ны өдөр анх мэдээлсэн хэлбэрийн дагуу олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулсугай.
6. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гарах шийдвэрийн төсөл, саналын хуудас, зэрэг холбогдох бусад баримт бичгийг бэлэн болгож, 2023 оны 11 дугаар сарын 22-ны өдрийн дотор хэвлэмэл болон цахим хэлбэрээр үнэт цаасны компаниудад хүргүүлсүгэй.
7. Санал авах хуудсаар урьдчилж санал өгөх сүүлчийн хугацааг 2023 оны 12 дүгээр сарын 21-ний өдрийн 16:00 цагаар тасалбар болгосугай.
8. Хурлын даргаар Хөвсгөл ХК-ийн ТУЗ-ийн дарга Г.Уянгыг томилсугай.

# “ХӨВСГӨЛ” ХК

9. Дараах нэр бүхий хүмүүсийг хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:
  - Хурал зохион байгуулах комиссын дарга:  
Э.Төртогтох
  - Хурал зохион байгуулах комиссын гишүүд:  
Ө.Ашхүү  
О.Нандинцэцэг
10. Дараах нэр бүхий хүмүүсийг хурлын Тооллогын комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:
  - Тооллогын комиссын дарга:  
Сноу Хилл Консалтанси ХХН-ийн Ахлах хуульч С.Намжилмаа
  - Тооллогын комиссын гишүүд:  
Сноу Хилл Консалтанси ХХН-ийн хуульч М.Даваажав  
Сноу Хилл Консалтанси ХХН-ийн хуульч З.Энхсүвд
11. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу Хурал зохион байгуулж, зар мэдээг хүргэж, энэхүү тогтоолын биелэлтийг хангаж ажиллахад шаардлагатай бүх арга хэмжээг авч ажиллахыг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
12. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад материалыг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан хугацаанд Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхийг гүйцэтгэх захирал Г.Сэлэнгэ-д даалгасугай.

